



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/64

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 129 дүгээр тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны “Сумын 2020 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Цахилгааны эх үүсвэрт холбогдоогүй иргэдийн өмчилсөн газарт байр зүйн зураг үйлдэх ажил”-д зарцуулагдах 2998655 /хоёр сая есөн зуун ерэн найман мянга зургаан зуун тавин тав/ төгрөгийг зарцуулсугай.

2. “Цахилгааны эх үүсвэрт холбогдоогүй иргэдийн өмчилсөн газарт байр зүйн зураг үйлдэх ажил”-д зарцуулагдах 2998655 /хоёр сая есөн зуун ерэн найман мянга зургаан зуун тавин тав/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч /О.Дөлгөөн/-д зөршөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 169